

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>1</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>2-20</i>

<i>1. Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 08 дугаар дүгнэлтийн тухай</i>	<i>2-20</i>
--	--------------------

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны
11 дүгээр сарын 05-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ц.Сандаг-Очир ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 32 гишүүнээс 18 гишүүн хүрэлцэн ирж, 56.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 26 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: О.Цогтгэрэл, Д.Энхтуяа;
Чөлөөтэй: Д.Амарбаясгалан, Б.Батбаатар, Л.Гантөмөр, Т.Доржханд,
Ч.Номин, Н.Номтойбаяр;
Эмнэлгийн чөлөөтэй: Л.Мөнхбаатар.

Нэг.Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 08 дугаар дүгнэлтийн тухай

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын ахлах зөвлөх Г.Агар-Эрдэнэ, Ж.Бямбадулам, С.Энхцэцэг, Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, зөвлөх Ц.Баянмөнх, Ч.Батбямба, референт А.Амармэнд, Б.Баясах, О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Байнгын хорооны дарга Ц.Сандаг-Очир хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтэд дурдсан асуудлыг цаашид хэрхэн, яаж шийдвэрлэх талаар гишүүд саналаа хэлэх боломжтойг танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун, Б.Баярбаатар, С.Зулпхар, О.Алтангэрэл, А.Ариунзаяа, Г.Уянгахишиг, П.Сайнзориг, Ц.Туваан, Ц.Идэрбат, Б.Хэрлэн, Х.Баасанжаргал, Ц.Даваасүрэн, Л.Оюун-Эрдэнэ, Б.Жаргалан, Ж.Баярмаа нар үг хэлэв.

Уг асуудлыг 12 цаг 32 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 06 минут үргэлжилж, ирвэл зохих 32 гишүүнээс 23 гишүүн хүрэлцэн ирж, 71.9 хувийн ирцтэйгээр 12 цаг 32 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Ц.САНДАГ-ОЧИР

Тэмдэглэл хөтөлсөн:

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим
11 цаг 26 минут.

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ц.Сандаг-Очир: Байнгын хорооны эрхэм гишүүдийн өдрийн амар амгаланг айлтгая. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Төрийн байгуулалтын байнгын хорооны 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. Чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдаанд ирсэн гишүүдийн ирцийг танилцуулъя. Оюунсайханы Алтангэрэл гишүүн, Аюушийн Ариунзаяа гишүүн, Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн, Баярмагнайн Баярбаатар гишүүн, Энхбатын Болормаа гишүүн, Сандагийн Бямбацогт гишүүн, Амгаланбаатарын Ганбаатар гишүүн, Сархадын Зулпхар гишүүн, Цагаанхүүгийн Идэрбат гишүүн, Чулуунбилэгийн Лодойсамбуу гишүүн, Эрдэнэбилэгийн Одбаяр гишүүн, Бөхчулууны Пүрэвдорж гишүүн, Цэндийн Сандаг-Очир, Отгоны Саранчулуун гишүүн, Цэвэгдоржийн Туваан гишүүн, Гончигдоржийн Уянгахишиг гишүүн, Бадарчийн Хэрлэн гишүүн, Өлзийхүүгийн Шижир гишүүн нар хүрэлцэн ирсэн байна. Ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны, Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Үндсэн хуулийн цэцийн 08 дугаар дүгнэлтийн тухай хэлэлцэнэ. Хэлэлцэх асуудалтай холбоотойгоор саналтай гишүүн байна уу? Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё. Хэлэлцэхийн өмнө Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 08 дугаар дүгнэлтийн Нэгтгэн дүгнэх хэсэгт энэхүү дүгнэлт Үндсэн хуулийн цэцийн эцсийн шийдвэр бөгөөд Улсын Их Хурал энэ талаар хүлээн зөвшөөрөх эсэх шийдвэр гаргахгүй гэж дүгнэсэн байгаа. Иймд өнөөдрийн хуралдаанаар Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хэлэлцэхгүй. Харин Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтэд дурдсан асуудлыг хэрхэн, цаашид яаж шийдвэрлэх талаар хэлэлцэж гишүүд саналаа хэлнэ.

Гишүүд, хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан үг хэлэх гишүүдийн нэрсийг авъя, нэрсээ өгнө үү? Болсон уу, Жаргалан ирцдээ орсон юм уу? Орчих. Нэрсээ өгөөрэй, ирцдээ ор эхлээд, тэгээд нэрдээ ор, нэрээ өг. Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ гишүүнийг нэмэх хэрэгтэй байна, Хэрлэн гишүүнийг, Жаргалан гишүүнийг, Зулпхар гишүүнийг, өөр, Батын Батбаатар гишүүн орсон уу, ирээгүй байна. Зулпхар гишүүнээр нэр авч дууслаа. Саранчулуун гишүүн үгээ хэлье.

О.Саранчулуун: Сайн байцгаана уу, Байнгын хорооны гишүүдэд өглөөний мэнд. Үндсэн хуулийн цэцийн шийдвэрээс болж улс орон даяараа маргаж, 2, 3 хуваагдаж, хуульч хүмүүс нь үг хэлэх эрхтэй, хуульч биш хүмүүс нь үг хэлэх эрхгүй гэдэг ийм байдалд хүрсэн. Би тэгвэл хуульч биш ч гэсэн нийгмийн ажилтан хүнийхээ хувьд энэ асуудал дээр үнэхээр эргэлзээ үүсгэж байгаа энэ байдал дээр нь өөрийн байр сууриа илэрхийлье гэж бодож байна. Монгол Улсын Үндсэн хуульд иргэн мэдээлэл авах эрхтэй байдаг. Иргэн гэдэгт нь зөвхөн хуульч иргэн гэж хэлээгүй

байгаа, бүх иргэд орж байгаа. Энэ асуудал дээр олон иргэдэд ойлгомжтой байх ёстой.

Дээрээс нь Монгол Улсын Үндсэн хуульд төрийн үйл ажиллагаа ил тод байх байх ёстой гэж заадаг. Ил тод гэдэг дотор нь аливаа хурал, үйл ажиллагаа эхэлсэн бол дуустал ил тод байх ёстой. Яг манай Байнгын хорооны хурал шиг, яг манай чуулган шиг анхнаасаа эхэлсэн бол дуустал нь иргэн буюу бүгд харах эрхтэй байдаг. Энэ 2 асуудал дээр би нийгмийн ажилтан хүнийхээ хувьд мэдээллийг үргэлж хоцордог иргэдийнхээ өмнөөс ч гэсэндээ би энэ дээр Үндсэн хууль зөрчсөн гэж үзэж байгаа учраас энэ дээр би ойлгоогүй учраас байр сууриа илэрхийлсэн өмнө нь. Үндсэн хуулийн цэцийн тухай хууль өөрөө цэц ил тод байх ёстой гэдэг дээр бас энэ Үндсэн хууль дээр болон Цэцийн ил тод байдал дээр ойлгомжгүй байгаа. Хуулийг бүх иргэн ойлгож хэрэглэдэг шиг нийгмийн ажилтнууд ч гэсэн, судлаачид ч гэсэн бүгдээрээ л ойлгодог. Тэгэхээр иймэрхүү ойлгомжгүй энэ шийдвэрүүд, дүгнэлтүүд өөрөө иргэдэд маргаантай асуудлыг бий болгож, иргэдийг талцуулж 2 хувааж байгаа нь өөрөө эв нэгдэл гэдэг асуудалтайгаа зөрчиж байгаа юм биш үү гэдэг ийм ойлголт, ийм эргэлзээ төрүүлж байгаа.

Тийм учраас миний ойлгож байгаагаар, миний бодлоор Цэц өөрөө ингэж дахин, дахин нэг асуудлыг удаан хуралдуулж байгаа юм шиг, удаан энэ асуудлыг маргааныг бий болгож байгаа юм шиг ийм нөхцөлийг бүрдүүлж байгаа учраас өөрсдөө энэ дээрээ тайлбарыг хийж болдоггүй юм уу. Иргэд ч гэсэн адилхан тайлбар хийдэггүй юм байх даа, энэ асуудлыг нэг тийш нь болгодоггүй юм байх даа гэж асууж байгаа байх гэж би бодож байна. Тэгэхээр энэ дээр ер нь хэн тайлбарлах юм бэ? Өнөөдөр Байнгын хорооны хурал дээр ажлын хэсэг гэж байхгүй, хоорондоо л ярих юм уу, бие биетэйгээ яриад ингээд дуусах юм уу. Энэ ч гэсэн ил тод байдал шүү дээ. Энийг ч гэсэн иргэд үзэж байгаа.

Тэгэхээр хэрвээ би Монгол Улсын иргэн юм бол бас адилхан энэ асуултыг асуух эрхтэй шүү дээ. Ойлгохгүй байгаа зүйлээ асуух хэрэгтэй. Яагаад энэ Үндсэн хууль дээр байгаа зүйлүүд тэр ил тод байдал, ойлгомжтой байх нь биелэхгүй байгаа юм бэ? Яагаад мэдээллээ авах эрх нь ойлгомжгүй, мэдээллээ авах эрх нь хангагдахгүй байгаа юм бэ гэдгийг тодруулмаар байгаа юм. Тэгэхээр ийм бодолтой байна.

Ц.Сандаг-Очир: Би хуралдаан эхлэхээс өмнө хэлсэн. Энд асуулт, хариулт байхгүй. Сая Хууль зүйн байнгын хороо яг мөн адилхан асуулт, хариултгүйгээр эндээс хэнээсээ асуух вэ. Тийм учраас гишүүдийг яг Цэцтэй холбогдуулаад, Цэцийн дүгнэлттэй холбогдуулаад үгээ хэлэх, байр сууриа илэрхийлэх энэ бололцоог хангах үүднээс өнөөдрийн энэ Хууль зүй болоод Төрийн байгуулалтын байнгын хороод явагдаж байгаа шүү. Тэгээд энэ хэлэлцүүлэг энүүгээр ч дуусахгүй байх. Цаашдаа ч гэсэн энэ Цэцийн дүгнэлттэй холбогдуулан олон хэлэлцүүлэг юмнууд, байр сууриа илэрхийлэх, эрдэмтэн судлаачид, хуульчдын дунд тэр олон асуудлууд, Цэцийн дүгнэлттэй холбогдуулаад үүсэж байгаа асуудлуудаар хүртэл тайлбар юу гарах юмнууд зөндөө гарах юм шиг байна.

Тийм учраас бид өнөөдрийн Хууль зүй болоод Төрийн байгуулалтын байнгын хороодыг гишүүдийг үгээ хэлэх, байр сууриа илэрхийлэх тэр бололцоо боломжийг хангах үүднээс хийж байгаа гэдгийг зөв ойлгоорой. Тийм учраас таны асуусан асуултад хэн нэг хүн хариулах Цэцийн өмнөөс хариулах тийм хууль зүйн боломж байхгүй гэдгийг хэлье. Баярбаатар гишүүн асуултаа асууя, юу үгээ хэлье.

Б.Баярбаатар: Гишүүддээ өглөөний мэнд хүргэе. Өнөөдөр Цэцийн 08 дугаар дүгнэлттэй холбоотой асуудлыг ярьж байна. Өнгөрсөн хугацаанд энд тэнд цэцэн мэргэн болоод л, янз бүрийн талаас нь, олон талаас нь ч ярилаа, нийгэм ч бараг энийгээ дагаад талцал хуваагдалд хүрч байх шиг байна. Мэргэжлийн судлаачид нь ч үйл ажиллагаа явуулж байх шиг байна.

Тэгээд нэг л зүйл байгаа юм л даа. Энэ дээр яах вэ зүгээр анхнаасаа л нээлттэй явах хурал хэвлэл мэдээллээр хаалттай болохоос авхуулаад, тусдаа хэлэлцэх ёстой асуудлыг нэгтгэж хэлэлцэхээс авхуулаад л нөгөө мордохын хазгай гэдэг шиг юм болчихсон юм л даа. Тэгээд үүнийгээ дагаад гарсан шийдвэр нь өнөөдөр ингээд процессын мухардалд хүргэчихсэн юм биднийг. Улсын Их Хурлын дэд дарга Булгантуяатай холбоотой асуудлыг хуулиар бол Их суудал хэлэлцэнэ гэхчихсэн байгаа юм. Тэгээд дүгнэлт үйлдээд гаргачихсан. Дүгнэлтийг нь эцсийн шийдвэрийг нь парламент гаргах ёстой байдаг. Гэтэл Цэцийн үндэслэл хэсэг дээрээ Их Хурал энийг хэлэлцэхгүй шүү гээд заачхаж байгаа. Дунд суудлын юу, тогтоолтой холбоотой асуудлыг дунд суудал хэлэлцээд, дүгнэлт үйлдээд, дүгнэлтийг Их Хурал хэлэлцээд, хүлээн зөвшөөрвөл тогтоолоо хүчингүй болгоод, хүлээн зөвшөөрөхгүй бол Их суудал хэлэлцээд, тогтоол батлаад буюу эцсийн шийдвэрийг Цэц дээр гаргах ёстой асуудал.

Энэ 2 асуудлын чинь нэгийг нь парламент эцэслэн шийднэ, нэгийг нь Үндсэн хуулийн цэц эцэслэн шийдэх л ийм асуудлыг өнөөдөр нэгтгэж хэлэлцээд, процессын мухардалд хүргэчихэж байгаа юм. Тэгэхээр энэ дээр сая Хууль зүйн байнгын хороо ч хуралдлаа. Тэгээд энэ олон гишүүд ярьж байна. Энэ Үндсэн хуулийн 66-н хоёрын 66.3-аа яах юм бэ л гээд байгаа шүү дээ. Цэцийн энэ дүгнэлт, тогтоол гээд 2 л юм яваад байгаа юм. Тогтоол нь бол эцсийн шийдвэр эрх зүйн акт. Дүгнэлт бол хууль зүйн санал шүү оруулж байгаа, Их Хуралд оруулж байгаа хууль зүйн санал нэг.

2-т тэгээд нэг ийм муу жишиг тогтлоо доо гэж бодоод байна. Албан тушаалтантай холбоотой асуудлыг Цэц их суудлаа хуралдуулаад эцсийн шийдвэр гаргачихсан гэж 08 дугаар дүгнэлт дээр дурдаж байгаа. Өнөөдөр яах вэ ингээд энэ асуудал явдаг юм байж. Бид Цэцийн шийдвэрийг буруу, зөв гэж ярихгүй, хүндэтгэлтэй хандах ёстой. Дараа дараагийн асуудлууд ингээд яах вэ жишээлбэл, хуульд заасан Ерөнхийлөгч, Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч, Ерөнхий прокурор, Улсын Их Хурлын дарга, гишүүн, Ерөнхий сайд гэсэн улсуудыг ингээд Цэцэд өгөөд, Цэц нь Их суудлаараа хуралдуулаад, шууд эцсийн шийдвэр гаргаад байдаг л ийм жишиг тогтчихлоо шүү дээ. Өнөөдөр Булгантуяа гэдэг хүн дээр ярьж байж магадгүй, дараа нь хэн нэгэн дээр.

Өнөөдөр энэ Монгол Улс эрх зүйт төрийн парламент засаглалтай улс. Парламентын засаглал нь ард түмнээсээ сонгогдож бүрддэг, мандат өвөртөлж энэ танхимд сууж байгаа. Энэ олон мянган мандатын асуудлыг Үндсэн хуулийн шүүхээр эцсийн шийдвэр гаргаад, хүчингүй болгодог ийм жишгийг хэдүүлээ хүлээн зөвшөөрөх үү гэдэг асуудал байгаа юм. 95 дугаар тогтоолыг хүчингүй болгох ийм процесс явахгүй юм уу. Энэ Цэцийн дүгнэлт дээр чинь яг хүчингүй болчихсон гэж бичээгүй байгаа шүү дээ. Тэгээд сүүлд нь хүчингүй болоогүй шүү дээ энэ чинь гээд ингээд буруу зөрүү, эргүүлээд тойруулаад гаргаад ирвэл яах юм. Их Хурал баталсан тогтоолоо Цэцийн дүгнэлтийн дагуу өөрсдөө хүлээн зөвшөөрөөд хүчингүй болгох асуудлыг уул нь процессын дагуу хийх ёстой юм болов уу л гэсэн хувь гишүүний бодол байна.

Төгсгөлд нь хэлэхэд энэ парламентын засаглалтай улс бол парламентаараа асуудлаа шийддэг, эцсийн шийдвэр эндээ гардаг ийм зайлшгүй шаардлага цаашид хадгалагдах ёстой шүү гэдгийг гишүүддээ хандаж хэлье. Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Баярбаатар гишүүн үгээ хэллээ. Сархадын Зулпхар гишүүн үгээ хэлье.

С.Зулпхар: Байнгын хорооны дарга, гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая. Цэцийн шийдвэр гарчихсан. Цэцийн шийдвэрийг бид хэлэлцэхгүй гэдгээ сая Байнгын хорооны дарга ч гэсэн хэлж байна. Угаасаа ч тийм байх ёстой гэдгийг бид Үндсэн хуулиа уншихад ч гэсэн тэгж ойлгож байгаа. Эрх мэдлийн жишээ нь хяналт тэнцлийнх нь хүрээнд аваад үзвэл бид хууль тогтоодог институт Улсын Их Хурлыг хэлж байгаа юм. Үндсэн хуулийн цэц бол шүүх эрх мэдлийн хүрээний жишээ нь институт. Энийг бид мэдэж байгаа. Бид Цэц гэж нэрлэсэн боловч олон улсад энийг чинь Үндсэн хуулийн шүүх л гэж нэрлэж байгаа шүү дээ. Шууд нэршил нь тэр. Тэр үүднээс нь аваад үзвэл Үндсэн хуулийн цэцээс гарсан шийдвэр хэрвээ эцсийнх гэж өөрсдөө тэрэн дээрээ маш тодорхой дурдсан бол тэрийг нь бид аваад явах нь гэдгийг та бүхэн бүгдээрээ энд хэлж байна. Энэ бол их чухал зөв ойлголт гэж бодож байна.

Гэлээ гэхдээ жишээ нь гишүүд маань 2 өөр асуудал дээр нэг тодорхой асуудал дээр нь ийм процессын эргэлзээ төрүүлсэн зүйл байна уу гэж ярьж байна. Энийг ярьж болно. Бид энийг ярих эрх нь Улсын Их Хуралд байгаа. Хэрвээ ямар нэгэн байдлаар хууль дээр процессын хувьд ийм зөрөөтэй гэдэг юм уу, эргэлзээтэй зүйл байгаа бол энийг ярих эрх нь зөвхөн Улсын Их Хуралд байгаа гэсэн л үг шүү дээ. Тэгээд цаашдаа хэрвээ ийм процессыг ямар нэгэн жишээ нь зохицуулалт дээр бидний хувьд эргэлзээ төрүүлэх ийм байдал үүсэж байгаа бол хууль санаачлаад энийгээ бид хуулиа боловсронгуй болгох ёстой. Нийгмийн улс төрийн хүрээний болон тэрэн дотроо жишээ нь төрийн тодорхой институтын харилцааг боловсронгуй болгох үүрэг нь биднийх гэсэн үг. Тэрийгээ бид цаашдаа хэрэв ярих бол ярих байх гэж бодож байна.

Үндсэн хуулийн цэц хуралдаан болоод, тодорхой шийдвэр гаргаж байгаа нь бид тэрэн дээр нэг зүйлийг сайн ойлгох хэрэгтэй. Энэ ардчилсан засаглалтай улсад хэрвээ ямар нэгэн байдлаар хууль зөрчигдөх, түүн дотроо Үндсэн хуулийн зөрчил бүхий нөхцөл байдал үүсвэл бие даагаад тэр асуудалд хяналт тавиад, тэр асуудлыг жишээ нь авч хэлэлцээд, хуулийн хүрээнд шийдвэр гаргадаг тийм институт ажиллаж байгааг бид сайшаах ёстой. Энэ бол манай ардчилсан дэглэмийн, ардчилсан засаглалын, парламентын эрх мэдлийн хяналт тэнцлийг хангасан энэ тогтолцооны давуу тал нь. Энэ давуу талаа бид цаашдаа ч гэсэн ингэж хадгалах ёстой юм гэж байгаа юм. Энэ улс төрийн нөхцөл байдал өнөөдрийн улс төрөөр хязгаарлагдахгүй. Цаашдаа ч гэсэн улс төрийн үйл явцад янз янзын нарийн ээдрээтэй нөхцөл байдлууд үүснэ. Ардчилсан засаглалд шилжээд 300 орчим жил болчихсон, Үндсэн хууль хэрэглээд 280 жил болчихсон улсад хүртэл тийм бэрхшээлүүд одоо ч гэсэн байж байгаа шүү дээ.

Тэгэхлээр бид цаашдаа ч гэсэн тийм нөхцөл байдалтай учирна. Гэхдээ тэр учирсан үедээ энийг харин өөр өөрийнхөө эрх мэдлийн хүрээнд, тухайн институтэд олгосон эрх, үүргийн хүрээнд энийг шийдээд, оролцоод явах ийм боломж нь байгаа шүү гэдгийг олон нийтэд бид ойлгуулж байх ёстой. Тэгэхгүй бол бид хэн нэгний эрх

мэдэл рүү, эсхүл тодорхой институтийн эрх мэдэл рүү ороод, эсхүл ямар нэгэн жишээ нь субъектийн эрхийг зөрчүүлээд байгаа ийм нөхцөл байдал үүсгэж болохгүй гэдгийг тал талдаа ойлгож байгаа юм байна гэж үзэж байна. Тэгээд бид мэдээж хэрэг энийг шийдвэрийг хэлэлцэхгүй гэхихсэн. Гэхдээ бид тодорхой асуудлаар саналаа илэрхийлж байгаа юм байна гэж ойлгож байна. Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Зулпхар гишүүнд баярлалаа. Алтангэрэл гишүүн үгээ хэлье.

О.Алтангэрэл: Өнөөдөр ингээд Хууль зүйн байнгын хороо, манай Төрийн байгуулалтын байнгын хороо нэг ийм тодорхойгүй асуудал хэлэлцээд байгаа юм шиг, хэлэлцэхгүй байгаа юм шиг л сууж байна л даа. Бид зарчмаа барина. Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт эцсийнх гээд ярьж байгаа юм. Тэгэхээр өнөөдөр бид ингээд хэлэлцэх гээд сууж байна. Гишүүдээс олон янзын санаа бодол гарч байгаа. Үүнийг дагаад манай ард иргэд ч гэсэн олон янзын эргэлзээ ойлголттой байна. Үгүй ээ энэ чинь аргагүй шүү дээ Цэц өнөөдөр, энэ болгон юунаас болж байна гэвэл би шууд Цэцээс болж байна л гэж хэлнэ.

Ер нь нэг зүйлийг анхаарах ёстой. Цэц бол Үндсэн хуулийн шүүх мөн үү мөн. Цэцийн шийдвэр эцсийнх үү эцсийнх гарна. Тэгэхдээ Цэцийн дээр Үндсэн хууль байгаа. Тэр Цэцийн дээр байгаа Үндсэн хуульд чинь төрийн эрх барих дээд байгууллага нь Улсын Их Хурал мөн гээд заачихсан. Хууль тогтоох эрх мэдэл бол халдашгүй шүү. Улсын Их Хурлын Үндсэн хуулиар олгогдсон бүрэн эрхүүд халдашгүй шүү. Энэ дээр ямар нэг ойлгомжгүй байдал үүсгэж, маргаан үүсгэж нэг шийдвэр гаргачхаад, олон нийтийн хэлэлцүүлэг талцал үүсгээд, ингээд Их Хурал нь буруутай ч юм шиг ийм байдал үүсгээд байгааг би шууд Цэцийн буруу гэж үзэж байгаа юм.

Яагаад тэр дунд суудлын хуралдаанаар шийдэх ёстой асуудал, Их суудлын хуралдаанаар шийдэх ёстой асуудлыг хольж шийдэж байгаа юм. Тэгээд хоёуланг нь түгжээд хаячхаж байгаа юм, яагаад эцсийнх гээд. Тийм бол бид одоо тэр асуудлыг нь яагаад яриад сууж байгаа юм. Гэтэл энэ Цэц чинь яг адилхан Үндсэн хууль дээр 1992 оноос хойш шийдвэр гаргаад явчихсан. Одоо ингээд Үндсэн хуулийн цэц дээр Улсын Их Хурлын гишүүдтэй холбоотой хэлэлцэж байсан зөндөө олон кейсүүд байна. Улсын Их Хурлын гишүүн Төрмандах Үндсэн хууль зөрчсөн байна гээд л гаргаж байсан байна. Улсын Их Хурлын гишүүн Элбэгдорж, Ганболд, Санжаасүрэнгийн Зориг, Улсын Их Хурлын дарга Гончигдорж, Нямдорж гээд хүмүүсийн талаар зөндөө олон шийдвэр гарч байсан.

Гэтэл жишээлбэл эндээс нэг жишээ авахад Монгол Улсын Их Хурлын дарга Цэндийн Нямдорж Үндсэн хууль зөрчсөн эсэх, түүнийг огцруулах үндэслэл байгаа эсэх талаарх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай гэж дүгнэлт гаргаад, жишээлбэл энэ дүгнэлт дээрээ Улсын Их Хурлын дарга Цэндийн Нямдорж Улсын Их Хурлын бүрэн эрхэд удаа дараа халдаж, Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн үйлдэл нь түүнийг Улсын Их Хурлын даргын албан тушаалаас огцруулах үндэслэл болно гээд. Ингээд тодорхой шийддэг, маргааныг шийддэг хуулиа баримталдаг үе манай Цэцэд байсан байна.

Өнөөдрийн энэ бүх маргаан энэ нэг цоожинд оруулж хаяад, Их Хурал шийдэж болох, шийдэж болохгүй хүрээнд Их Хурлыг ингэж түлхэж хаяад, өөрсдийн эрх мэдлээ зүй зохистой Цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хууль болон Цэцийн тухай хуулиа хэрэгжүүлэхгүй хаячихсаны л үр дагавар. Яригдах асуудал зөндөө

байгаа. Тухайлбал Цэцийн шийд, Цэцээр шийдвэр гарсны дараагаар тухайн гаргасан тушаал шийдвэрийн үр дагавартай холбоотой зохицуулалт Цэцийн хуульд байгаа шүү дээ. Энийг хэн ч ярихгүй. Ингээд нэг ийм ойлгомжгүй байдал үүсээд, Их Хурал дээр асуудал авчирч наагаад байгаа нь Цэцийн буруу. Ингэж үзэж байгаа би бол.

Тэгээд тэр хуралдааны тухай, одоо нэг Цэцийн тэр нэг хурал дүгнэлтэд дурдагдсан хуралдааны тухай асуудал яриад байгаа шүү дээ. Бид ер нь хариуцлагатай байх ёстой. Би тэр хуралдааны танхимд өөрийн биеэр сууж байсан. Тэр шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцсон. Тэгээд Улсын Их Хурал буруутай гэж үзэж байгаа бол тэнд сууж байсан хүмүүстэйгээ хамт миний бие хариуцлагаа хүлээмээр байна. Нэг аргалаад юм уу, нэг хүнийг түлхээд юм уу, худал, үнэн хууль тайлбарлаад юм уу энэ юмнаас бултаад зайлаад явъя гэсэн бодол алга.

Гол өнөөдөр бидний бодох ёстой зүйл Цэц ингээд цаашдаа хэм хэмжээгээ даваад, Үндсэн хуулийнхаа хэм хэмжээг сахиулах үүргээ бусад хууль тогтоомж болон нийтэд урд нь тогтоосон жишиг, манай ерөнхий энэ хуулийнхаа үндсэн рамаас гажаад ингээд гаргаад байвал Улсын Их Хурал болон парламентын энэ эрхийн асуудал цаашаа юу болох юм бэ? Ийм учраас Цэц өөрөө шийдвэр гаргах болгондоо хариуцлагатай байж, дунд суудлын хуралдаанаараа шийдэх асуудлаа дунд суудлын хуралдаанаараа, Их суудлын хуралдаанаар шийдэх асуудлаа Их суудлын хуралдаанаараа шийдэж баймаар байна. Бүгд өөр өөрсдийнхөө үүргийг гүйцэтгэмээр байна. Цэр нь цээжиндээ, бөөр нь бөгсөндөө. Бүгд өөр өөрсдийнхөө хийх ёстой үүргийг хууль зүйн дагуу, Үндсэн хуульд заасны дагуу хэрэгжүүлэх ёстой.

Ц.Сандаг-Очир: Алтангэрэл гишүүн үгээ хэллээ. Ариунзаяа гишүүн үгээ хэлье.

А.Ариунзаяа: Алтангэрэлтэй санал нэг байна, аргагүй Хууль зүйн сайд ч байсан хүн, хуулийн хүн. Төрийн эрх барих дээд байгууллага бол Их Хурал юм. Харин Их Хурал Засгийн газраа итгэл үзүүлэх үү, үгүй юу, ажиллуулах уу, ажиллуулахгүй юу гэдэг нь энэ гаргах шийдвэр нь ч гэсэн Улсын Их Хурлын бүрэн эрх юм гэдгийг энд дахин нотолж хэлмээр байна.

Тухайн өдрийн процесс ер нь юу болсон юм бэ гэдгийг бид протоколд хэлж үлдээсэн нь зүйтэй байх гэж бодож, энэ үгийг авч хэлж байна. Улсын Их Хурлын гишүүд Засгийн газрыг огцруулах өргөдөл гаргаж, Төрийн байгуулалтын байнгын хороогоор хэлэлцэж, дөнгөж Төрийн байгуулалтын байнгын хорооны шийдвэр буюу дэмжихгүй гэдэг шийдвэр гармагцаа Улсын Их Хурлын чуулган эхлээгүй, дөнгөж ирцийн бүртгэл явагдаж байгаа тэр үед Цэцэд хандсан. Цэц Улсын Их Хурлаар эцсийн шийдвэр гараагүй байхад таамаглал дээр үндэслэж хэрэг үүсгэсэн байдаг, маргаан, маргаан үүсгэсэн байдаг. Энэ 1 дүгээр алдаа нь шууд харагдаж байгаа.

2 дахь нь Цэцийн тухай хууль нь өөрөө хоног хугацаатай энэ маргаан шийдвэрлэх, маргаан нээх бүхий л асуудлуудыг хуульчилсан байдаг. 23 дугаар зүйлийнхээ 3 дээр онц болон дайны байдал зарласан, түүнчлэн цэрэг хөдөлгөх шийдвэртэй холбогдсон маргааныг хянан шийдвэрлэх бэлтгэл ажиллагааг 3 хоногийн дотор гүйцэтгэнэ гэж 3 дээр заасан байгаа. Цэцийн дарга тухайн үедээ энэ асуудал онц хүндрэлтэй асуудал учраас үүнийг яаралтай авч хэлэлцэхийг зөв гэж үзсэн гэж хэлсэн. 4 дээр болохлоор онц хүндрэлтэй, яаралтай шийдвэрлэх асуудлыг хянан хэлэлцэх хуралдааны бэлтгэлийг хангахын тулд Цэцийн даргын тогтоолоор 2

буюу хэд хэдэн гишүүнийг томилон ажиллуулж болно гэж заасан. Энэ бол 2 буюу түүнээс дээш гишүүнтэй бас ажиллуулаагүй. Нэг л хүн дээр энэ асуудлыг хариуцуулсан.

Цэцийн хуулийн 24 дүгээр зүйлийн 3 дээр Цэцийн гишүүн нь хуралдааныг нээлттэй буюу хаалттай хийх, энэ хуралдааныг олон нийтэд зарлахдаа зөвхөн 3 дугаар зүйлд заасан буюу энэ онц болон дайны байдал зарласан үед л 3 хоногийн дотор байна. Бусад тохиолдолд долоо хоногийн хугацааны товтой байна, долоо хоногийн өмнө төрийн энэ төв хэвлэлд зарлаж нийтэлнэ, хурлаа зарлана гэж заасан. Тэгэхээр онц хүндрэлтэй, яаралтай асуудал гэж үзэж байсан бол ядаж долоо хоногийн хугацаа өгөх ёстой байсан. Гэтэл 3 хоногоор л шахаж явсан. Булгантуяа дэд даргад өмгөөлөгч авах эрхийг ч өгөөгүй. Үндсэндээ хүний эрх талаас нь үнэхээрийн Булгантуяа гэдэг хүний хүний эрхийг нь зөрчсөн. Ямар нөлөөлөлтэй байсан, яасан ийсэн гэдгийг нь хэлж мэдэхгүй юм.

Энэ 38 хуудас дүгнэлт ирүүлэхдээ яагаад дунд суудал болон Их суудлаар энэ явах ёстой процессынхоо дагуу явуулаагүй вэ гэхлээр 2 өөр шийдвэр гаргах магадлалтай байсан учраас Их суудлаараа хэлэлцэнэ гэж байгаа байхгүй юу, гэж өөрсдөө энэ дүгнэлтдээ бичсэн байгаа юм. Тэгэхээр юу гэсэн үг вэ гэхлээр урьдчилан төлөвлөсөн тэр дүгнэлт гарахгүй л бол бид ийм процессыг алгасаж ингэж явж байна гэдэг нөхцөл байдлыг л өөрсдөө дүгнээд гаргачхаж байгаа юм. Ямар дүгнэлт гарсан бэ гэдэг нь ойлгомжтой.

Тэгэхээр хэзээ нэгэн цагт судлаачид эрдэмтэд, Үндсэн хуулийн манаачид яг юу болчхов гэдгийг өөрсдөө харж, дүгнэх цаг ирэх байх гэж бодож байна. Энэ дүгнэлттэй мөн түүнчлэн дахиад л Үндсэн хуулиа өөрсдөө зөрчсөн буюу.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Ариунзаяа гишүүн нэмэлт 1 минут.

А.Ариунзаяа: Дүгнэлтдээ Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийг, 66 дугаар зүйлийн 2-ыг зөрчөөд, Улсын Их Хурлаар авч хэлэлцэхгүй, энэ шийдвэр эцсийнх гээд гаргачхаж байгаа. Тэгээд шийдвэр ч гэж дээ, тогтоол ч эцсийн байдлаар гаргаагүй дүгнэлт гээд орхичихсон.

Одоо нөгөө алдарт 95 дугаар тогтоол хүчинтэй юм уу, хүчингүй юм уу, эцсийн шийдвэр гарч байгаа юм уу, гараагүй юм уу, тогтоол юм уу, үгүй юм уу ийм маргаантай нөхцөл байдлыг үүсгэхдээ байна. Тэгээд хэний үгээр 95 автоматаар хүчингүй болж байна гэж үзэх вэ, хэн нэгэн дараа нь гарч ирээд үгүй ээ та нар энийг хүчингүй болгох ёстой байсан шүү дээ, энэ Үндсэн хуулийнхаа 62 дугаар зүйлийг мөрдөөгүй байна, дахиад Үндсэн хууль зөрчсөн байна гэсэн асуудал гаргахлаар юу болох вэ? Хэрэвзээ одоо Засгийн газар үүрэг гүйцэтгэгч байгаа бол 30 хоногийн дотор жинхлэх ёстой энэ асуудал чинь эргээд л нөгөө нөхцөл байдлыг маш сонин хүнд нөхцөл байдалд оруулах гээд байгаа байхгүй юу. Тэгэхээр ер нь ингээд Цэц өөрөө маш маргаантай асуудлыг бий болголоо шүү гэдгийг хэлье.

Ц.Сандаг-Очир: Уянгахишиг гишүүн үгээ хэлье.

Г.Уянгахишиг: Миний хувьд яг агуулгатай холбоотой юм хэлэхгүй. Яг процесстой холбоотой яг үнэндээ нэг их маргаантай зүйл харагдахгүй байгаад байгаа. Өөрөөр хэлбэл Үндсэн хуулийн цэц асуудлаа яаж шийдсэн бэ гэдэг

асуудлаа ярихаас өмнө бид Үндсэн хуулиа баримтлах ёстой. Тэгэхээр Үндсэн хуулийн 66 дугаар зүйл дээр маш тодорхой, Цэц хэрхэн шийдвэр гаргах вэ гэдгийг тодорхойлоод биччихсэн. Энд юу гэсэн бэ гэхээр Үндсэн хуулийн цэцээс албан тушаалтан Үндсэн хууль зөрчсөнтэй холбоотой асуудал, эсвэл Их Хурлын тогтоол, эсвэл хуулийг анхан шатаар буюу энэ дээр жишээлбэл дунд суудал, Их суудал тэр тухай ерөөсөө байхгүй. Зүгээр тэр асуудлыг шийдээд дүгнэлт гаргана.

Энэ гаргасан дүгнэлтийг 2 дугаар зүйл дээр нь юу гэж байгаа вэ гэхээр, 3 дугаар зүйл дээр юу гэж байгаа вэ гэхээр 1, 2-т заасны дагуу оруулсан дүгнэлтийг гэж байгаа юм. Энэ нь юу вэ гэхээр нөгөө Их Хурлын тогтоолтой холбоотой, эсвэл хуультай холбоотой тэр маргааныг шийдсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрөөгүй бол Үндсэн хуулийн цэц дахин хянан үзэж, эцсийн шийдвэр гаргана. Өөрөөр хэлбэл энд Үндсэн хууль дээр Их суудал байна уу, бага суудал байна уу ерөөсөө байхгүй. Тэгэнгүүт Цэц яадаг вэ гэхээр энэ Үндсэн хуулиа хэрэгжүүлэхийн тулд маргаан шийдвэрлэх тухай хуультай. Тэр хуулийг Их Хурал баталдаг. Маргаан шийдвэрлэх хууль дээрээ юу гэж бичсэн байна вэ гэхээр албан тушаалтан Үндсэн хууль зөрчсөнтэй холбоотой асуудлыг бид Их суудлаараа хуралдаад, дүгнэлт гаргачихна. Яагаад гэвэл нөгөө эцэслэдэг учраас гэдгээр.

Хууль болон Их Хурлын тогтоолтой холбоотой асуудлыг яадаг вэ гэхээр дахиж хянан шийдвэрлэх буюу Их Хурал руу буцаад, Их Хурал хэлэлцэх боломжийг нь Үндсэн хуулиараа өгөх ёстой учраас Дунд суудлын хурлаараа шийддэг ийм процесстой. Одоо 95 дугаар тогтоолтой холбоотой болон Улсын Их Хурлын дэд дарга Булгантуяатай холбоотой асуудал хэлэлцэгдэхдээ энэ Их суудлын хурлаар хэлэлцэх, эсвэл дунд суудлын хурлаар хэлэлцэх гэдэг энэ өөрийнх нь Цэцийн маргаан шийдвэрлэх дэг нь алдагдсан буюу нэгтгээд шийдвэрлэчихсэн. Тэрийгээ Цэц өөрөө процессоо тэгж нэгтгэнэ үү яана уу тэр бидэнд хамаа алга. Хамгийн гол нь Цэц өнөөдөр тогтоол гаргаагүй, Цэц өнөөдөр дүгнэлт гаргачихсан. Өөрөөр хэлбэл Үндсэн хуулийн 66 дугаар зүйлд заасан Үндсэн хуулийн дүгнэлт гарчихсан.

Тэгэхээр бид энэ 95 дугаар тогтоолтой холбоотой Үндсэн хуулийн дүгнэлтийг Их Хурал өөрийнхөө дэгийн 84 дүгээр зүйлийн дагуу авч хэлэлцэх ёстой. Энийг тэгж болохгүй гэдэг заалт хаана ч байхгүй, хуулийн ямар ч зохицуулалт алга. Тэгэхээр яг энэ хуулийн зохицуулалтаар яагаад маргаан гаргаад байгааг би ойлгохгүй байгаад байна. Өөрөөр хэлбэл бид хууль дээр хамгийн түрүүнд Үндсэн хуулийн асуудлаа шийднэ, органик хуулиуд дээр зөрчилдөөн үүсвэл бид дээшээгээ Үндсэн хууль руугаа очдог. Тэгэхээр Үндсэн хуульд энэ маш тодорхой заагдчихсан байгаа учраас бид Үндсэн хуулийн цэцийн 08 дугаар дүгнэлтийг авч хэлэлцэхдээ Дүгнэлтийн 1 дүгээр хэсэг буюу албан тушаалтантай холбоотой асуудлыг эцэслэн шийдвэрлэсэн гэдгийг хүлээн зөвшөөрөх ёстой.

2 дугаар асуудал буюу Улсын Их Хурлын 25 оны 95 дугаар тогтоол Үндсэн хууль зөрчсөн гэдэг дүгнэлтийг бид Их Хурал өөрийнхөө эрх хэмжээний хүрээнд Үндсэн хуулийнхаа дагуу хянан хэлэлцэх ёстой. Энэ дээр ямар ч маргаан байхгүй. Тэгэхээр бид энэ дээр Хууль зүйн байнгын хороо ч тэр, Төрийн байгуулалтын байнгын хороо ч тэр хуульд заасныхаа дагуу Үндсэн хуулиа бариад, Их Хурлынхаа дэгийг бариад, Дэгийн хуулийг бариад 84 дүгээр зүйлийнхээ дагуу 95 дугаар тогтоолоо дахиад хэлэлцэх ёстой. Хэрвээ Үндсэн хуулийн цэцийн 08 дугаар дүгнэлтийг би тэр суудал ерөөсөө яриагүй шүү, 08 дугаар дүгнэлтийг үндсэн, хүлээн.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Уянгахишиг гишүүн 1 минут.

Г.Уянгахишиг: Тэгэхээр байнгын, Хууль зүйн байнгын хороо болон Төрийн байгуулалтын байнгын хорооны Үндсэн хуулийн цэцийн 08 дугаар дүгнэлтийн 2 дахь, дүгнэлт хэсгийн 2 дахь хэсэг буюу Улсын Их Хурлын 95 дугаар тогтоолтой холбоотой Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн авах эсэх тухай асуудлыг бид Хууль зүйн байнгын хороо болон Төрийн байгуулалтын байнгын хороогоороо оруулаад, чуулганыхаа нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх ёстой. Энэ дээр ямар ч маргаан байхгүй гэж үзэж байна.

Ц.Сандаг-Очир: Гишүүдээ 4 минутаас явж байгаа юм байна шүү. Тэгэхээр нэмэлт 1 минут байхгүй юм байна. Түрүүнд Ариунзаяа гишүүн дээр 3 минут, асуулт, хариултын 3 минутаас явчихсан учраас 1 минут өгсөн. Одоо бол цаашдаа 4 минутаар явж байгаа учраас нэмэлт минут байхгүй юм байна гэдгийг хэлье. Сайнзориг гишүүн үгээ хэлье.

П.Сайнзориг: Өнөөдөр тэгэхээр бид хэд 1992 онд байгуулсан нийгмийн гэрээний асуудлын хэрэгжилтийг яаж зөв авч явах вэ гэдэг асуудлыг ярьж байгаа юм. Энэ гэрээний нэг тал маань өөрөө ард түмэн, нөгөөдөх нь буюу ард түмнийг төлөөлөх хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдэл байгаа. Тэгэхдээ энэ эрх мэдлүүдийн харилцан тэнцлийн асуудал дээрээ төрийн эрх барих эрх мэдэл нь хууль тогтоох байгууллагад хадгалагдаж байгаа гэдэг зүйлийг Монгол Улсын Үндсэн хууль үг, үсэггүй, товч, тодорхой утгын ямар нэгэн хоёрдмол байдалгүйгээр хийсэн байж байгаа, зохицуулсан байж байгаа.

Тэгэхээр өнөөдөр 33 жилийн хугацаанд олон нийт ч тэр, зарим хууль тогтоож байгаа парламентын гишүүнээр ажиллаж байгаа хүмүүс маань төрийн эрх мэдэл хаана хадгалагддагийг ч мэдэхгүй ингэж олон нийтийг төөрөгдүүлж байгаа нь туйлын харамсалтай байгаа. Өнөөдөр төрийн эрх мэдэл энэ муу ч, сайн ч ард түмнээсээ мандат аваад сонгогдож байгаа энэ парламентад хадгалагдаж байгаа юм. Түүнээс биш Засгийн газарт биш шүү. Засгийн газартаа хариуцлага тооцож байгаа парламент төрийн эрхийг хууль бусаар авна гэсэн зүйл ерөөсөө байхгүй. Тэгэхээр бид хэд энэ зүйлээ ойлгохгүй урвуу хамааралтай нь авч үзвэл харин дарга буюу дарангуйлал тогтоох дараагийн алхам руу орж байна гэсэн үг.

Тэгэхээр би олон нийтдээ хандаж байгаа юм. Энэ 126 гишүүд ямар ч байсан та нөхдийг төлөөлөөд 4 жилдээ хариуцлагаа хүлээгээд, сонгуулийн үр дүнгээрээ та бүгдийнхээ өмнө улаан нүүрээрээ зогсож байдаг хүмүүс ямар ч байсан та нөхдийн мандатыг төлөөлөөд байж байгаа юм. Та нөхдөд хадгалагдаж байгаа энэ эрх мэдлийг зөв хэрэгжүүлэхийн төлөө байж байгаа. Тэгэхээр энийг 1 дүгээрт зөв ойлгоосой гэж хүсэж байгаа юм.

2 дугаарт энэ нийгмийн гэрээний нэг тал ард түмэн буюу ард түмнийг төлөөлж парламент байгаагийн хувьд энэ Үндсэн хуулийн үг, үсэг, цэг, таслалыг хамгаалах эрх нь парламент буюу манаач нь өөрөө парламент. Бид хэд хэт уянгалаад байгаа юм. Энэ Үндсэн хуулийн цэц чинь Үндсэн хуулийн манаач энэ тэр гээд. Үгүй ээ, энэ аливаа институт хоорондын үүсэж байгаа, дээрээс нь энэ тодорхой албан тушаалтан Үндсэн хууль зөрчиж байгаа гэдэг маргааныг шийдэж өгч байгаа болохоос биш энэ эрх мэдэл тэнцлийнхээ хувьд хамгийн эцсийн зогсоол буюу энэний үг, үсэг амьдралыг цаашдаа зөв авч явах институт нь өөрөө парламент юм байгаа юм. Хууль тогтоох институтынхээ хувьд ч тэр, энэ улсын гадаад, дотоод

асуудлыг авч хэлэлцэх бүрэн эрхтэйн хувьд ч ерөөсөө энэ байж байгаа юм. Тэгэхээр энийг 1 дүгээрт ойлгоосой гэж хүсэж байгаа юм.

2 дугаарт нь нэгэнт Цэц маргааныг шийдээд өгсөн учраас энэ улс төрийн мэдрэмж гэдэг юм уу, тодорхой зүйл дээр хөтлөгдөхгүйгээр Үндсэн хуулийнхаа үг, үсэг, цэг, таслалыг л дагаж энэ асуудлуудыг бид авч хэлэлцмээр байгаа юм. Энэ дээр гишүүд маань анхаарч өгөөч гэдэг зүйлийг хүсэж байгаа юм. Өөрөөр хэлбэл уг нь дүгнэлтийг Улсын Их Хурал хэлэлцээд, хүлээж авах эсэхээ шийдээд, Цэц эцсийн шийдвэрээ гаргана. Ингээд явбал хамгийн зөв байсан уг нь. Тэгэхдээ нэгэнт шийдвэр гарсан учраас энэтэй холбоотой асуудлуудыг зөв болгочихъя гэдэг зүйлийн дагуу л энэ Ерөнхий сайдыг огцруулах эсэх асуудал дээр гаргасан 95 дугаар тогтоолыг хүчингүй болгоосой гэж хүсэж байгаа юм. Энэ хүчингүй болгохгүйгээр явбал кодификац хийж болохгүй, 30 хоногийн дараа шинэ Ерөнхий сайдаа томилж чадаагүй гэдэг үндэслэлээр Улсын Их Хурал тарна. Энэ харин жинхэнэ хямрал руугаа явж байгаа.

Цэц энэ шийдвэрийг хүчингүй болгохдоо үг, өгүүлбэрийн хувьд маш тодорхой гардаг энэ шийдвэрээс өмнө. Энэ хуулийн ийм хэсэг, зүйл, заалтыг хүчингүй болгосугай гэдэг зүйлийг тогтоох хэсэг юм уу, дүгнэлтийнхээ дүгнэх хэсэг дээр гаргадаг. Тэрнээс биш үндэслэх хэсэг дээр янз бүрийн юмнуудыг дурддаг. Энэ бол тухайн тэр шийдвэрийг гаргах хэргийн нөхцөл байдлуудыг дурдаж байгаа фактуудыг ийм, ийм зүйлүүд тогтоогдлоо гэдэг зүйлийг ярьж байгаа болохоос биш үндэслэх хэсэг дээрээсээ баримталж бид хэд тийм юм байна гэж ерөөсөө хэлж болохгүй. Тийм учраас энийг уг нь 95 дугаар тогтоолыг яаралтай, цаг алдалгүй хийхгүй бол ийм дараагийн улс төрийн хямрал руу орох нь гэдэг зүйлийг 1 дүгээрт хэлмээр байгаа юм.

Тэгээд ер нь Булгантуяа даргын асуудал дээр Засгийн газар нэхэмжлэлээ нэмэгдүүлсэн байдаг юм. Тангаргаасаа няцсан эцсийг тогтоож өгөөч гээд. Цэц тэрийг нь авч хэлэлцээд, тангаргаасаа няцсан зүйл ерөөсөө байхгүй байна буюу ямар ч байсан Дэгийн хууль зөрчигдсөн байна гэдэг зүйлийг хэлсэн. Уг нь Дэгийн хуультай холбоотой ямар ч маргаан Цэц.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Туваан гишүүн үгээ хэлье.

Ц.Туваан: Бүгдээрэнд нь энэ өглөөний мэнд хүргэе. Тэгээд гишүүд хэлж байна, Монгол Улс парламентын засаглалтай орон гээд. Эрх мэдэл энэ парламентад хадгалагдах ёстой гээд. Тэгэхээр одоо эргэлзээтэй болж байна л даа. Эрх мэдэл Цэцэд хадгалагдаж байгаа юм шиг ийм байдал ажиглагдаж эхэллээ. Би бол хуульч биш, тэгэхдээ энэ дээр ингээд ер нь хөндлөнгийн байр сууринаас, иргэдийн байр суурь энэ тэрийг ч гэсэн ингээд сонсохоор 2 хуваагдчихаад байна зөв ч юм шиг, буруу ч юм шиг ийм байдал үүсчхээд байна. Амьдрал баян учраас энэ Цэц дээр маргаан шийдвэрлэгдэх хууль энэ тэр дээрээ хэдүүлээ хууль тогтоогч нар юм бол одоо энэ кейс дээр бас засаж залруулах боломж нь бидэнд байгаа. Бид өөрсдөө энийгээ засаж залруулъя, илүү тодорхой болгоё.

Тэгэхгүй бол энэ чинь ингээд бүүр маш тодорхойгүй, маш их зүйл хоорондоо холилдоод ингээд явж байна л даа. Жишээлбэл би өнгөц юунаас ингээд харахад энэ албан тушаалтны асуудлыг бол Их суудлаар хэлэлцэнэ гээд гэж байх шиг байгаа юм 1 кейс. 2 дугаарт энэ Улсын Их Хурлын тогтоол, шийдвэртэй холбоотой асуудлыг дунд суудлаараа хэлэлцэнэ гэж байх шиг байгаа юм. Энэ 2 асуудал.

Тэгсэн чинь энэ асуудлыг ингээд нэгтгээд хэлэлцчихэж байгаа юм. Тэгээд ер нь ингээд практикаас харахад нэг асуудал дээр 2, 3 талаас өргөдөл өгвөл энийг нэгтгэж хэлэлцэж болдог. Өөрөөр хэлбэл агуулга ижил зүйлийг. Бусад агуулга ондоо зүйлийг нэгтгэж хэлэлцээд, асуудал хэлэлцчихсэн учраас энэ дээр энэ асуудал гараад байна уу гэж ингэж ярьдаг. Тэгээд бид мэдээж нэг иргэдээс сонгогдоод, саналаа аваад ингээд ирж байгаа иргэдийн төлөөлөл. Цэцээ бид өөрсдөө томилдог. Цэцийн 3 гишүүнийг бид Их Хуралд томилдог, Ерөнхийлөгч томилдог, нөгөө 3-ыг нь хэн ч томилдог билээ ингээд. Цэц маань одоо асуудалтай шийдвэр гаргавал яах вэ, улс төржсөн шийдвэр гаргавал яах вэ энэ зүйлүүдийг бид ер нь бодолцмоор л юм билээ.

Цэцийн шийдвэрийг бид хэлэлцэхгүй гээд энэ дээр гаргачихсан. Зарим ямар шийдвэрүүд нь хэлэлцэгдээд байдаг юм би бас ойлгохгүй байна. Цэцийн шийдвэрүүд чинь орж ирээд л, Цэцийн дүгнэлтийг хэлэлцье гээд л бид чинь хэлэлцээд л, олонх нь дэмжсэн, дэмжээгүй гээд ингээд л явдаг шүү дээ. Зарим нь яагаад хэлэлцэхгүй ингээд гардаг юм, энэ асуудал нэлээн бидний хувьд эргэлзээтэй байна гэдгийг бас хэлье.

95 дээр 3 асуудал тавьсан юм шиг байгаа юм. 2-ыг нь шийдчихсэн, шийдчихсэн гэж ойлгож байгаа. Мэдээж Цэцийн шийдвэр учраас энэ албан тушаалтантай холбоотой юу, нэг нь юу байлаа, тэр 3 дахь асуудал шийдэгдээгүй гэдэг дээр гишүүдийн үгэнд ч гарч байна. 95 дугаар тогтоол чинь тэгээд яах юм бэ, энийг хүчингүй болгох юм уу, болгохгүй юм уу энэ дээр нэг тийм эргэлзээ харагдаад байгаа юм. Тэгэхээр гэх мэтчилний зүйлүүдээс нэлээн тийм иргэдийн дунд ч тэр, бидний дунд ч, бид хууль тогтоогчид гээд өөрсдөө ийм эргэлзээтэй байхад ард иргэд, бусад хүмүүсийн дунд бол тодорхой л байна л даа. Тэгэхээр ер нь хэдүүлээ энэ асуудлуудыг нэлээн ярилцаад, кейсүүдийг нь ярилцаад, засаж залруулах зүйл байвал цааш нь засаж залруулаад явах нь зүйтэй байх гэж бодож байна. Тэгээд энийг дүгнэлтийг хэлэлцэж байна гэж үзэх үү, яаж байна гэж үзэх вэ. Байнгын хороод маань хүртэл ийм тодорхойгүй байдлаар хуралдаж байна л даа. Тэгэхээр тодорхойгүй зүйл их байна, засаад явцгаая гэж хэлэх гэсэн юм.

Ц.Сандаг-Очир: Идэрбат гишүүн үгээ хэлье.

Ц.Идэрбат: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Энэ Үндсэн хуулийн цэцтэй холбоотой асуудал дээр Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр сонгогдож, томилогдож оролцсон. Тэгээд энэ Цэцийн хурлын процессуудыг харахаар хуульч гишүүдийн хэлж байгаа, тавьж байгаа тэр шаардлагуудыг харахаар нөгөө талуудын тэнцвэртэй байдал гэдгийг ер нь огт хангахгүйгээр л хурал хийчхэж байна уу даа гэж миний хувьд харагдсан. Тэр битгий хэл нээлттэй гэдэг юмаа зарчмаа хүртэл үгүйсгээд, танхимд оруулахгүй, гадаа байгаа зурагтаа хүртэл унтраачихна гэхээр чинь тэр чинь хаалттай хийх сонирхол маш их байсан юм байна л гэж миний хувь хүний хувьд дүгнэгдсэн.

Би өөрөө хуульч хүн биш. Тийм учраас ялангуяа энэ Үндсэн хуулийн цэцтэй холбоотой асуудал дээр тэр болгон яаран байр сууриа илэрхийлэхийг хүсээгүй. Гэхдээ Үндсэн хуулийн цэцийн хурлын өмнө хуульчид Үндсэн хуулийн дээр хөх тэнгэр байгаа энэ бол эцсийн шийд гээд ингээд л янз бүрээр л тайлбарлаад байсан. Үндсэн хуулийн цэцийн шийдвэр гарсны ард дээр ердөө тэгж энэ Цэцийн дүгнэлттэй холбоотой байр сууриа илэрхийлж байгаа хүн бол бараг байхгүй болсон. Гончигдорж гуай хэлж байгаа, Тэмүүжин гишүүн хэлж байгаа юм. Яг энэ маань

Үндсэн хууль нэлээдгүй зөрчил гаргачихлаа шүү гээд. Саяын гишүүдийн хэлж байгаа зүйлийг энэ хүмүүс нэлээн углуургатай яриад байгаа юм л даа. Тэгээд миний хувьд энэ дээр үг хэлэхээсээ өмнө энэ Үндсэн хууль судлаачдын, энэ хуульчдын байр суурийг сонсохыг нэлээн хичээсэн.

Тэгээд яах вэ энэ дээр үндсэндээ Үндсэн хууль маань Үндсэн хуулийн цэцийн тухай хууль, Үндсэн хуулийн цэц маргаан хянан шийдвэрлэх тухай гэсэн энэ 3 хуулийн хүрээнд л өөрийн хэмжээнд судалсан. Тэгээд энэ дээр Цэц би энэ тогтоол орж ирэх юм байна даа гэж бодож байсан дүгнэлт гээд ингээд л ороод ирсэн. Хэрвээ энэ 3 хууль дээр дүгнэлт байгаа бол энэ Их Хурал энийг чинь хэлэлцэх ёстой юм байна лээ шүү дээ. Баярбаатар гишүүн Цэцийн дүгнэлтийг хэлэлцэх ёстой гээд хэлснийхээ төлөө л тэнэг мангараараа дуудуулаад л бөөн юм болсон. Гэхдээ өнөөдөр ингээд л яг хэлэлцээд сууж байна л даа. Гэхдээ өнөөдөр эндээс ямар ч үр дүн би гарахгүй юм байна л гэж ингэж харж байгаа юм.

Тэгэхээр ер нь цаашдаа энэ Монгол Улсын төрийн энэ харилцан хяналттай байх энэ зарчим ер нь одоо тэгээд яах юм бэ? Энэ Үндсэн хуулийн цэцийн хуулиараа энэ дүгнэлтийг чинь хэлэлцэх ёстой. Тогтоол гаргачихсан бол энэ чинь нэг өөр хэрэг юм байна шүү дээ. Тэгэхээр өнөөдөр ямархуу дүр зураг анзаарагдаад байна гэхээр Үндсэн хуулийн дээр хөх тэнгэр бий, та нар тайлбарлах үүрэггүй гэсэн хэр нь л хэдэн хүмүүс тайлбарлаад байгаа байхгүй юу өөрсдийнхөөрөө. Тэгээд яах вэ зүгээр хэрвээ цаашдаа бид ингээд нэг жоохон алдаа байдаг бол тэрийгээ засаад явахгүй бол энэ 08 дугаар тогтоол гарснаас хойших энэ бүх процесс чинь өөрөө Үндсэн хууль зөрчсөн гэдэг ийм юм руугаа би орчих вий дээ л гэж миний хувьд энэ саяын хэлдэг 3 хуулийг хараад л надад тийм сэтгэгдэл төрж байгаа юм.

Тэгээд дараа нь засаж сайжруулах зүйл байх ёстой гэж байна. Үнэхээр Цэц энэ гаргасан шийдвэрүүдээ ирж тайлбарладаг тэр хууль, эрх зүйн орчныг нь гаргаж өгөхгүй бол энэ чинь дуртай нь тайлбарлаад ингээд яваад байж болохгүй нь. Яах вэ тэгээд эцсийн дүндээ аливаа юм сайн, муу талтай, тэгээд Цэц дээр ийм маргаан үүссэнээс шалтгаалаад нийгэмд маш их хэлэлцүүлэг, шүүмжлэлүүд өрнөлөө. Тэгээд эндээс нэг л үр дүн би гарч эхэлж байна уу даа гэж харж байгаа. Юу гэхээр Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дээр хөх тэнгэр бий гэдэг энэ хэн хэлсэн нь мэдэгдэхгүй энэ нэг философи бас нэг энэ хуульч гишүүд янз янзын байдлаар ингэж тайлбарласны үр дүнд Цэцийн дээр Үндсэн хууль нь байдаг гэдэг нэг ийм ололттой юм руугаа л нэг явж байна уу даа л гэж би зүгээр дүгнэж байгаа юм. Тэгэхээр өнөөдрийн энэ Байнгын хорооны хурлууд ингэж хийсний яг бодит үр дүн нь юу байх юм бэ, тэгээд хариулах хүн байхгүй юм чинь.

Ц.Сандаг-Очир: Хэрлэн гишүүн үгээ хэлье.

Б.Хэрлэн: Бүгдээрэнд нь энэ өдрийн мэнд хүргэе. Тэгэхээр Үндсэн хуулийн цэц дээрх энэ маргааныг шийдвэрлэх энэ хуралдаанд би ажиглагчаар оролцсон, эхнээс нь дуустал тэнд суусан. Ерөнхийдөө энэ кейс бидэнд хууль тогтоогчдын хувьд нэлээн том сургамж болсон ийм үйл явдал болж байна. Тэгэхээр саяын үг хэлсэн хүмүүсийн дотор хэд хэдэн санаанууд 2, 3 санаануудыг би нэг жаахан лавлаж тодруулах хэрэгтэй юм байна гэж бодож би үгээ хэлье.

Тэгэхээр Үндсэн хуулийн цэцийн маргааныг шийдвэрлэх тухай хуулийн 31.2-т Үндсэн хуулийн цэц гаргаж байгаа шийдвэр нь 3 хэлбэртэй байна гэж заасан байдаг. Энэ шийдвэрийн хэлбэр нь болохоор дүгнэлт, тогтоол, магадлал гэсэн ийм

3 хэлбэртэй. Өнөөдөр энэ 08 бол дүгнэлт хэлбэрээр гарсан бөгөөд өөрийнхөө дүгнэлтэд бичсэнээр Үндсэн хуулийн цэцийн Их суудал хуралдсан тохиолдолд энэ бол эцсийн шийдвэр буюу эцсийн дүгнэлт байна гэж энд дүгнэлтэд тодорхой бичсэн байгаад байгаа юм. Тэгээд энэ утгаараа Үндсэн хууль зөрчсөн тухай асуудлаар гарсан бүх шийдвэр нь эцсийн байх бөгөөд Улсын Их Хурал энэ талаар хүлээн зөвшөөрөх эсэх шийдвэр гаргахгүй гэж энэ 08 дугаар дүгнэлтэд биччихсэн байгаад байгаа юм. Өөрөөр хэлбэл энэ шийдвэр нь дүгнэлт хэлбэртэйгээр гарчихсан, ахиж хэлэлцэх нөхцөл бүрдэхгүйгээр ийм гарчихжээ гэдгийг л энэ дүгнэлтэд тодорхой биччихсэн байна гэж байгаа.

Тэгээд Үндсэн хуулийн 67 дугаар зүйлд Үндсэн хуулийн цэцээр шийдвэр гармагцаа хүчин төгөлдөр болно гэсэн ийм заалт байгаа. Өөрөөр хэлбэл бид энийг хэлэлцэх, хүлээн зөвшөөрөх эсэх нь үл хамааран энийг хэрэгжүүлээд явах ёстой юм байна гэсэн ийм зохицуулалт бий. Тэгэхээр энэ хүрээнд бид ажиллах байх гэж бодож байна. Өнөөдрийн хурал ерөнхийдөө энэ Үндсэн хуулийн цэцээс гаргасан эцсийн шийдвэрийн мөрөөр цаашдаа бид яг ямар арга хэмжээ авах юм бэ, тэр нөгөө 95 дугаар тогтоолын тухай асуудал яах вэ 1 дүгээрт, 2 дугаарт Үндсэн хууль зөрчсөн гэж дүгнэлт гараад байгаа Улсын Их Хурлын дэд дарга Булгантуяагийн тухай асуудлууд энд хөндөгдөх байх л даа.

Тэгэхээр энэ асуудлууд ямар хуулиар зохицуулагддаг юм бэ гэхээр ерөнхийдөө бид үзэхэд Үндсэн хууль, түүнчлэн Улсын Их Хурлын тухай хууль, Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хууль гэсэн ийм 3 хуулиар энэ бол зохицуулагдаж байгаа. Ялангуяа Үндсэн хуулийн цэцийн энэ дүгнэлтийг хүлээж аваад, Улсын Их Хурлаас цаашдаа ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэх вэ гэдэг нь Чуулганы дэгийн тухай хуулийн 84, 85, 86, 87 дугаар зүйлүүдээр зохицуулагдсан байгаа. Нэгэнт эцсийн шийдвэр гээд гараад ирчихсэн байгаа тохиолдолд энэ бол бид 1 дүгээрт эцсийн шийдвэр гээд гараад ирчихсэн, хэлэлцэх нь утгагүй болоод явчхаж байна.

Хэрвээ албан тушаалтан Үндсэн хуулийг зөрчсөн тухай асуудлыг хэлэлцвэл магадгүй энэ нь болоод ирэхээр Дэгийн тухай хуулийн 86, 85 энэ зохицуулалтуудын хүрээнд энэ хэлэлцүүлэг цаашаа явах байх. Тэгэхээр энэ Байнгын хорооны хурал, Төрийн байгуулалтын байнгын хорооны хурал арай жаахан илүү асуудлыг авч шийдсэн, ач холбогдолтой байхын тухайд өнгөрсөн процессын тухай ярихаасаа илүүтэйгээр бид цаашдаа яах юм бэ, энэ гараад ирсэн шийдвэрийг одоо яг амьдрал дээр авч хэрэгжүүлэхийн тухай дээр бид яг цаашдаа хуулийн хүрээнд ямар арга хэмжээнүүдийг авч явуулбал бидэнд боломж байгаа юм бэ гэдгийг тогтож яривал илүү үр дүнтэй болно байх гэж би бодож байна. Тэгэхээр цааш цаашдынхаа хэлэлцүүлгийг ер нь энэ рүү чиглүүлэх нь илүү өгөөжтэй байна.

Ц.Сандаг-Очир: Хэрлэн гишүүн үгээ хэллээ. Баасанжаргал гишүүн үгээ хэлье.

Х.Баасанжаргал: Би 2 зүйл дээр анхаарлаа бүгдээрээ хандуулах ёстой болов уу гэж бодож байна. 1 дүгээрт бид өнөөдөр Цэцийн дүгнэлтийг буюу Цэцийн дүгнэлтийн агуулгыг хэлэлцэхгүй, түүний үр дагаврыг хэлэлцэж байгаа ийм процесс ажиллагаа явагдаж байгаа. Гэхдээ үр дагаврыг нь хэлэлцэхээр буцаад эргээд агуулга руу бид ороод байна л гэсэн үг. Үр дагавар дээрээ төвлөрөөдөхье. Дүгнэлт дээр 2 зүйлийг заасан. Энэ 2 зүйлд заасан үр дагаврыг бид хэлэлцэх гэж байгаа.

Гэхдээ хоёуланг нь хэлэлцэхгүй, зөвхөн Булгантуяа гишүүнтэй холбоотой асуудлыг хэлэлцэж байгаа нь өөрөө яагаад гэдэг асуултыг тавиад байгаа байхгүй юу.

Хэд хэдэн асуулт энэ Цэцийн дүгнэлттэй холбоотой гардаг. Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хэлэлцэх үү, хэлэлцэхгүй юү гэдэг нэг ийм асуулт гардаг. Яагаад гэвэл дүгнэлт гээд биччихсэн байгаа учраас Үндсэн хуульд заасны дагуу Үндсэн хуулийн 66.3-д заасны дагуу хэлэлцэх ёстой байгаад байдаг. Гэтэл Цэц өөрөө дүгнэлт дээрээ хэлэлцэхгүй гээд заачихсан байгаад байдаг. Энэ чинь нэг ийм маргааны асуудал болоод байна гээд.

Хэрвээ хэлэлцэхгүй гэвэл тэгвэл үр дагаврыг нь яагаад хэлэлцээд байгаа юм бэ? Үр дагаврыг нь хэлэлцэх ёстой гэвэл яагаад 2 үр дагаврыг хэлэлцэхгүй нэгийг нь хэлэлцээд байгаа юм. Зөвхөн нэг үр дагавар буюу зөвхөн Булгантуяа гишүүнтэй холбоотой зөвхөн ийм субъектив тэр маргаан, энэ асуудлыг бид анхаарлаа хандуулж хэлэлцвэл нөгөө нэг үр дагавар нь яах юм бэ, нээлттэй үлдэх юм уу? Нөгөө нэг үр дагавар буюу Засгийн газрыг огцруулсан 95 дугаар тогтоол яах юм бэ, 95 дугаар тогтоолыг яах юм бэ хэлэлцэхгүй үлдээж байгаа гэсэн үг юм уу, дараа нь хэлэлцэнэ гэсэн үг юм уу? Сая Хууль зүйн байнгын хороо кодификац хийнэ гээд ингээд алх тогшихлоо.

Энэ дээр Их Хурлын Тамгын газар кодификац хийх ямар ч боломж байхгүй шүү дээ хууль зүйн хувьд. Яагаад гэвэл хэрвээ тогтоолыг хүчингүй болгож байгаа бол хүчингүй болгосон гэдгээ Цэц дандаа бичиж, тэмдэглэж ирсэн, дүгнэлт дээрээ бичдэг байсан. Ганцхан энэ удаа бичээгүй. Их Хурлын Тамгын газар үндсэндээ бас гацаанд орчихсон. Тэгээд энэ асуудлуудыг хэдүүлээ төвлөрч, энэ процессуудыг зөвтгөх асуудлуудыг ярих хэрэгтэй. Яагаад процессыг зөвтгөх гээд байгаа юм гэвэл энэний цаана парламентын дархлаа гэдэг юм байна. Парламент цаашид яах юм бэ, Цэц дүгнэлт гаргаад тогтоол биш шүү, Цэц дүгнэлт гаргасны дараа Цэц ямар ч хамаагүй Их Хурлын үйл ажиллагаатай холбоотой дүгнэлт гаргаад л, тэрийг нь бид хүссэн, хүсээгүй Цэц дүгнэлт дээрээ манай дүгнэлтийг та нар хэлэлцэхгүй шүү гэхээр “за” гээд л явдаг болох юм уу?

Тэгээд ер нь явж, явж парламентын дээр Цэц нь өөрөө гарч, Цэц нь илүү том шийдвэр гаргах болох гээд байна шүү дээ. Гэтэл Цэц чинь өөрөө улс төрийн томилгоотой байгууллага. Энэ дээр тэгээд үе үеийн улс төрчид, үе үеийн манай намын хүмүүс ч гэсэн энэ дээр хариуцлага хүлээх ёстой. Хуулийн байгууллага Цэцийг ямагт улс төрийн ийм үйл ажиллагаандаа ашиглаж ирсэн. Тэрний бас л нэг тод жишээ болж Цэц өөрөө мөрөө үлдээлээ. Тэгэхдээ маш харамсалтайгаар мөрөө үлдээж байна. Хаана ч байхгүй дайн бүхий, онц бүхий байдалд холбоотой мэтээр ингэж тайлбарлаж, онцгой нөхцөл байдал үүссэн гэж ингэж маш хурдан хугацаанд Цэц анх удаагаа 30 жилийн дараа хэрэг шийдлээ.

Би хуульч байсан хүний хувьд энэ хуулийн байгууллага, Цэц, шүүх гээд энэ байгууллагуудыг үнэхээр улс төрөөс хараат бус, бие даасан байгаасай гэж чин сэтгэлээсээ хүсдэг. Гэхдээ энийг бид улс төрчдөөс хүлээж болохгүй юм байна лээ. Улс төрчид бол ойлгомжтой, ямар л бол ямар аргаар улс төрийн тэмцлээ хийдэг. Харин энэ хуулийн байгууллагууд өөрсдөө дархлаатай болох тухайгаа одоо ярих ёстой болсон. Энийг одоо ингээд бүгдээрээ Цэц ёстой нээрээ мундаг шийдвэр гаргасан, Цэц ёстой гээд ингээд магтан дуулаад өнгөрч болохгүй. Энэ угаасаа судалгааны эргэлтэд орох ёстой. Тийм учраас би одоо манай энэ Байнгын хороо

ямар ч шийдвэр гаргаж чадахгүй, зүгээр л уншаад сонсгоод өнгөрч байгаа. Тэгвэл яах гэж ингэж сонсгож.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Даваасүрэн дарга, гишүүн үгээ хэлье.

Ц.Даваасүрэн: Тэгэхээр энд нэг ийм ноцтой юм нь төрийн эрх мэдлийг хууль бусаар авсан гэдэг юм яригдаад байгаа юм. Хэн авчав гэдэг асуудлыг бид заавал тодотгох хэрэгтэй болчихоод байгаа юм. Булгантуяа мэдээж дэг дээр байхгүй зүйлээр санал хураалгаж болохгүй шүү дээ. Дэг дээр огт байхгүй. 43.1 дээр Ерөнхий сайдыг огцруулах асуудлаар гэж байгаа юм. Үгүй ээ, бид Ерөнхий сайдыг огцруулахыг дэмжээгүйг дэмжье гээд уг саналыг л хураасан шүү дээ. Тэгээд л Ерөнхий сайд огцорсон шүү дээ. Хэнд ч ойлгомжтой шүү дээ, огцруулахаас өөр юмаар хураагаагүй шүү дээ бид. Тэгээд энэ Их Хурлыг Үндсэн хуулийн 27.1-д чуулганы хэлбэрээр шийдвэрээ гарга гэхчхсэн байгаа юм. Чуулганы хэлбэрээр гэдэг чинь тэр Байнгын хороо, нэгдсэн хуралдааныг хэлж байгаа байхгүй юу. Байнгын хороо саналаа бэлтгэж оруулна, нэгдсэн хуралдаанаар түүнийг сонсож шийднэ л гэсэн үг шүү дээ. Энэ тэгэхээр Үндсэн хуулийн 27.1-ээр явсан байна.

Нөгөө талаараа Үндсэн хуулийн 28.2-т Байнгын хорооны эрхийг хуулиар тогтоогоорой гээд Үндсэн хууль дээр хэлээд өгчихсөн. Тэгээд Улсын Их Хурлын тухай 22.3-аар Байнгын хорооны эрхийг тогтоосон байгаа та нар хараарай. Байнгын хорооны эрхийн 23-ын, 22.3.7-д Их Хурлаас томилсон Ерөнхий сайдыг огцруулах, томилох, эгүүлэн татах санал гаргана гээд байж байгаа байхгүй юу. Үгүй ээ ингээд биччихсэн юмыг чинь яаж Булгантуяа орхиод, санал хураалгах юм бэ. Тэгээд Үндсэн хуулийн дагуу бүх юм явагдсан байна шүү дээ. Дэгийн хуулийн 101.3 дээр Байнгын хорооны санал, дүгнэлтийг сонсоод, илээр санал хураана. Үгүй ээ сонсоод гэдэг чинь тэр саналыг уншихаар хураа гэсэн үг биз дээ. Ийм ... юун дээр бид Цэц Үндсэн хууль зөрчсөнийг зүгээр яриад өнгөрч ингэж болохгүй. 3 удаа ийм алдаа гаргалаа.

2015 онд Баярцогтыг огцруулах асуудал дээр яасан Их Хурал Засгийн газрын гишүүнийг огцруулах эрхгүй гэж Их Хуралд халдаад, аварч үлдсэн. Халдаад шүү. Харин тэр үед Их Хурлын дарга З.Энхболд хатуу хүн байсан хүн тул Цэцийн даргыг буцааж татсан. Хариуцлага тооцсон.

2 дахь асуудал нь юу болсон 21 онд. 2016 оны Цэц эцсийн суудлаараа гаргасан Үндсэн хуульд пропорциональ элемент байхгүй байна гэж, одоо жагсаалт байхгүй байна гэдэг шийдвэрийг хүчингүй болгоод, дахиад Их суудлаараа хуралдаж байгаад Үндсэн хуульд пропорциональ байж болно гээд хийчихсэн байхгүй юу. Гэх мэтээр ингээд хууль зөрчөөд, энэ 3 дахь нь, одоогийнх 3 дахь нь. Ингээд Үндсэн хууль зөрчөөд манаач маань яваад байвал яах юм бэ гэдэг асуудал. Энийг хэн авч хэлэлцэх юм бэ, энэ чинь даамжраад байна шүү дээ. Их Хурал авч хэлэлцэх ёстой, тэр Энхболд шиг хариуцлага ярь л даа. Өөрийнхөө илгээсэн 3-ыг тат л даа, энийг ингээд зүгээр ингээд орхиж болохгүй. Нэг өдөр энд харийн сэтгэлтэй 9 хүний 6 нь суучхаад, Үндсэн хуулийн тусгаар тогтнолын заалтыг аваад хаячихвал тэгээд яах юм бэ бид. 6-хан хүнээр шийдүүлэх юм уу. Эцсээрээ суусан, эцсийн суудлаараа шийдсэн ингээд ангайгаад сууж байх уу? Тэгэхээр ингэж хариуцлагагүй хандаж бид болохгүй. Тэгэхээр илгээсэн байгууллага нь энэ илгээсэн 3 дээрээ хариуцлагаа ярь.

Тэр 66.2.1 дээр байгаа тогтоолын асуудлыг дүгнэлт гарсан учраас бид Их Хурал зөвшөөрөх, зөвшөөрөхгүйгээ ярих ёстой байх. Энийг хэдүүлээ анхаарах ёстой. Дээр нь нэмээд энэ Үндсэн хууль зөрчсөн илгээсэн 3 хүнээ татах асуудлыг

ярих ёстой шүү. Тэгж байж бид энэ Үндсэн хуулийн цэцийн энэ Үндсэн хуулиа зөрчиж байгаа асуудлыг хязгаарлаж чадна. Тэгэхгүй бол цаашдаа ч зөрчинө. Тийм учраас бид энэ дээр хариуцлагатай хандаж ингэж явмаар байна. Тэрнээс биш одоо.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Оюун-Эрдэнэ гишүүн үгээ хэлье.

Л.Оюун-Эрдэнэ: Эрх баригчид талцлаасаа болж анхаарал нь сулраад, сөрөг хүчин эрх баригчдын дотоод асуудал гэж үзэж анхаарал нь сулраад, бүхэлдээ парламент сонор сэрэмжээ алдсан байх үед Үндсэн хуулийн цэц ийм шийдвэр гаргалаа л даа. Үндсэн хуулийн энэ Цэцийн шийдвэр илтэд улс төрийн захиалгат шийдвэр. Энэ бол маш ойлгомжтой. 3 хоногийн дотор цэрэг хөдөлгөх онц байдлын дэгээр шийдсэн. Тийм учраас бид өнөөдөр энэ асуудлыг их нухацтай ярихгүй бол дараа нь Цэц ямар, ямар шийдвэрийг ч гаргах юм, энийг парламент анхааралдаа авах нь зүйтэй. Одоо бид энэ олон хоногийнхоо хөөсийг буулгаад, бодитойгоор парламентын засаглалд энэ асуудал ямар зүйл цаашид учруулж болох вэ гэдгийг харах ёстой.

Тэгээд миний бодлоор нэг хэд хэдэн ийм үр дагавруудыг авчрах магадлалтай гэж үзэж байгаа юм. 1 дүгээрт Үндсэн хуулийн цэц ер нь Их Хурлын эцэслэн шийдвэрлэгдсэн шийдвэр нь Үндсэн хуульд нийцсэн үү, үгүй юү гэдгийг л хянадаг. Тэрнээс биш парламентын гал тогоон дотор орж ирээд, саналын томьёоллыг нь зааж өгөөд, Их Хурлын гишүүд саналаа яаж өгөхийг нь зааж өгөөд, тэгээд ингэж санал хураахгүй бол татна гэдэг асуудлыг ярьдаг ийм эрхтэй байгууллага биш. Энийг бид засахгүй бол цаашдаа парламент утгаа алдана. Төрийн байгуулалт ч биш бусад бүх Байнгын хороод санал хурааж яах юм бэ тэгвэл. Тэгээд бүүр парламентын ирцэд орох юм уу? Хажуу айлынхаа гал тогоон дотор ороод хамаг юмыг нь уудалж үзээд байх юм уу ингээд. Энэ чинь харилцан хяналт тэнцэлтэй өөр, өөр байгууллагууд. Нэг нь Үндсэн хуулийн шүүх, нэг нь хууль тогтоох байгууллага. Тэгэхээр энэ бол их тийм ноцтой зөрчигдсөн асуудал 1 дүгээрт боллоо гэж миний хувьд зүгээр үзэж байгаа. Энийг зүгээр цаашдаа бид бодох л ёстой зүйл.

2 дугаарт Цэц бол парламентын засаглалын амин сүнс болсон парламентын олонх Засгийн газраа байгуулж, хариуцлага тооцдог зарчмыг эвдчихэж байгаа юм. Цаашдаа парламент дээр биш, Цэцийн 9 гишүүнтэй учраа олчихвол ингээд Засгийн газарт яг хариуцлага тооцож чадахгүй ийм жишиг рүү явна гэсэн үг парламент. Нэг үгээр хэлбэл олонхын биш, цөөнхийн засаглал бүрдэх, парламентын дуу хоолой үлэмж хэмжээгээр сулрах ийм нөхцөл байдал руу орох ийм томоохон асуудал энэ 126-тай парламентын эхний кейс болсон ийм сорилт болж байна гэж үзэж байгаа юм. Тэгэхээр энийг бодох ёстой зүйл.

Дээрээс нь энэ дүгнэлт өөрөө хурал удирдсаны төлөө, хурал удирдаж байгаа арга барил нь зарим хүмүүст таалагдаагүйн төлөө татъя гэдэг асуудал ярьж байна. Хурал удирдаж байгаад татагдчихдаг болчихвол тэгвэл энэ ард түмний мандат яах юм бэ? Ажлын хэсэг байгуулаад, жоохон галтай сэдэв бариад авбал тэгээд татагдчихвал яах вэ? Энэ өөрөө парламентын дархлааг үлэмж хэмжээнд сулруулах, хуулийн хонгилоо яая гэж байж, Цэцийн хонгилыг яах вэ гэдэг ийм асуудалтай тулна шүү.

Ц.Сандаг-Очир: Жаргалан гишүүн үгээ хэлье.

Б.Жаргалан: Би Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүн биш боловч яг энэ Үндсэн хуулийн цэцийн 08 дугаар дүгнэлт дээр байр сууриа заавал хэлж, үгээ хэлэх ёстой гэж бодоод орж ирсэн. Яагаад вэ гэхлээр өнгөрсөн хугацаанд уг асуудалтай холбоотой нийгэмд маш ихээр ийм талцал хуваагдал үүсэж, улс орон даяараа бараг Үндсэн хууль судлаач болчихлоо шүү дээ. Тэгэхээр юуны өмнө эрх баригч Монгол Ардын намынханд хэлэхэд та бүхний энэ эрх мэдлийн төлөөх тэмцэл, энэ их улс төржилт нийгэмд маш их хуваагдлыг бий болгоод зогсохгүй, маш их үзэн ядалтыг бий болгоод зогсохгүй, давж болохгүй бүх шугамуудыг даваад, ийм жолоодлогогүй ийм үзэн ядалт руу түлхэж байна.

Тэгээд сүүлдээ бүр төрийн бүх институтүүд оролцоод эхэлсэн Засгийн газар, Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Үндсэн хуулийн цэц. Бид ингэж суурь тогтолцоогоо эвдсэн, ардчилсан Үндсэн хуулиа эрсдэлд оруулсан ийм улс төржилтийг хүлээн зөвшөөрч болохгүй. Тэгэхээр та нөхдийг энэ бүх асуудлуудаа хойш нь тавиад, тангараг өргөсөн Улсын Их Хурлын гишүүдийн хувьд асуудалд ийм объектив байдлаар хандаад, цаашдаа бид яг энэ Үндсэн хуулиа хамгаалах, парламентын дархлаагаа хамгаалах талаар юу хийж болох вэ гээд ийм өөр яриа руу ороосой гэж хүсэж байна 1 дүгээрт.

Тэгээд өнгөрсөн хугацаанд юу болоод өнгөрөв, 54 гишүүн гарын үсэг зураад Засгийн газрыг огцруулъя гэсэн саналыг өргөн барьсан. Уг саналыг Улсын Их Хурал авч хэлэлцээд, 71 гишүүн ухамсартайгаар, идэвхтэйгээр Засгийн газрыг огцруулъя гээд шийдвэрээ гаргасан. Гэвч харамсалтай нь манай 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд тэр 43.1 гэдэг заалт дээр угаасаа ийм саналын томъёолол бүхий ийм процессын заалт орчихсон байсан. Тэгээд энэ саналын томъёолол дээр Их Хурал алдаа гаргасан гэдгийг нь Үндсэн хууль сая, Үндсэн хуулийн цэц сая тогтоожээ. Тэгэхээр одоо Их Хурал дээр процессын алдаа гарсан байна гэж үзэж байна.

Нөгөө талаас Үндсэн хуулийн цэц дээр маш их процессын алдаа гарсан тийм ээ. Хоног хугацаатай холбоотой, эрх бүхий албан тушаалтантай холбоотой асуудлыг Улсын Их Хурлын шийдвэртэй холбоотой асуудалтай хольж хутгаад Их суудлынхаа хуралдаан руу аваачсан гэх мэт хаана хаанаа бид маш их тийм алдаатай зүйлүүдийг хийчихлээ. Одоо энэ алдаануудаа яаж засах вэ гэдэг асуудал яригдаж байна. Тэгэхээр яаж засах вэ гэхлээр 1 дүгээрт Үндсэн хуулийн цэцийн энэ 08 дугаар дүгнэлт дээр 2 асуудлыг дүгнэх нь гээд 1 дүгээрт нь, Булгантуяатай холбоотой асуудлыг томъёолчихсон байж байгаа, эрх бүхий албан тушаалтантай холбоотой асуудлыг бол Улсын Их Хурал авч хэлэлцэхгүй, шийдвэр эцсийн байна.

2 дугаар зүйлээр болохлоор Засгийн газрыг огцруулсан 95 дугаар тогтоолтой холбоотой асуудал Үндсэн хууль зөрчсөн гээд үзчихэж байгаа юм. Энэ Улсын Их Хурлын шийдвэртэй холбоотой асуудал дээр бол Улсын Их Хурал хүлээн зөвшөөрөх эсэх тухай асуудлаа шийдэх ёстой. Тэгэхээр өчигдөр Ардчилсан намын бүлэг хуралдаад энэ Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөх ёстой гээд бас нэг шийдвэр гаргасан. Тэгэхээр өнөөдөр бид энэ 95 дугаар тогтоолтой холбоотой энэ дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх эсэх, зөвшөөрөх тухай ийм тогтоолын төсөл дээр ажиллах ёстой юм биш үү. Тэгж байж ядаж эхний ээлжид энэ голдирлоо зөв зам руу засна.

Цаашдаа энэ Төрийн байгуулалтын байнгын хороон дээр ажлын хэсэг гаргаад, яг энэ нөхцөл байдалтай холбоотой хуулийн хийдлүүд хаана байна вэ, энэ

процессын алдаанууд яагаад гараад байна вэ гэдэг дээр Дэгийн тухай хууль, Улсын Их Хурлын тухай хуультай, хуульд өөрчлөлтүүд оруулах ийм ажлын хэсэг гаргая гэсэн санал байна. Бид ийм бүтээлч байдлаар энэ улс төрийн хийрхлээ зогсоогоод асуудалд хандахгүй бол цаашлаад энэ Үндсэн хуулийн чинь асуудал бүүр сөхөгдөж тавигдах нь гэсэн саналтай байна.

Ц.Сандаг-Очир: Жаргалан гишүүн үгээ хэллээ. Жудагийн Баярмаа гишүүн үгээ хэлье.

Ж.Баярмаа: Та бүгдийн амрыг эрье. Үндсэн хуулийн цэц маань 2 дүгнэлт гаргасан бүгд мэдэж байгаа 1, 2 гээд. 2 дахь нь буюу 43.1-ийг зөрчсөн гээд дүгнэлт гаргачихсан. Тэрийг нь бид хүлээж аваад байгаа юм, юм шиг байгаа юм. Зөвшөөрөөд байгаа юм. Тэгсэн мөртөө тэр 43.1-ийг зөрчсөнтэй холбоотой хэн хариуцлага хүлээх вэ гэдэг асуудлыг ингээд ярьж болохгүй гээд байгаа юм. Тэгэхээр тэр нэгэнт Үндсэн хууль зөрчсөн нь тогтоогдоод, бид тэр 43.1-ийг зөрччихсэн юм бол яагаад, хэн энийг зөрчсөн юм бэ, зөрчүүлэв гэдэг асуудлыг ярихаас өөр замгүй болж байгаа юм.

Тэгэнгүүт одоо бид тэр доторх агуулгыг ярихгүй, үр дагаврыг ярина гэж байгаа юм. Зөв, үр дагавар. Тэгэнгүүт нөгөө нэг дээр ийм, ийм Үндсэн хуулийг, одоо би нэр бол хэлмээргүй байна. Монгол Улсын Их Хурлын гишүүн тэр нь ийм, ийм 43.1 гээд ийм, ийм Үндсэн хуулийг гэснийг зөрчсөн байна гээд ингээд дүгнэлт гаргачихсан. Дүгнэлт бол хэлбэрээр гарна гээд түрүүн Хэрлэн гишүүн маш тодорхой хэллээ шүү дээ. Дүгнэлт, магадлал, тогтоол гээд. Тэгэхээр энэ дүгнэлт хууль ёсных мөн юм уу, мөн байна. Энэ дүгнэлтэд зөрчсөн гээд гарч уу гарч. Тэгэнгүүт одоо үр дагавар нь юу болох ёстой юм бэ, Үндсэн хуулийг зөрчсөн хүмүүс яах ёстой юм бэ гэдэг асуудлыг л бид ярих ёстой гэж би ойлгоод байгаа юм.

Тэгэхээр Улсын Их Хурлын гишүүн Үндсэн хууль зөрчвөл яах вэ гээд дахиад энэ хуулиудад чинь заачихсан байгаад байна. Тэр битгий хэл Үндсэн хуулийн 29.3-д нь заачихсан байна шүү дээ. Тэгээд нэг ийм юм яриад байна л даа. Үндсэн хуулиа л барих ёстой гээд байна. Энэ Цэцийн дүгнэлт падгүй гээд байх шиг байна бас, ер нь явж, явж сүүлдээ. Тэгвэл ер нь Цэцэд хандах шаардлага үүсэх юм уу, үгүй юм уу. Бүгдээрээ Үндсэн хуулиа бариад л ажиллаад байя л даа. Бүгдээрээ өөрснөө Үндсэн хуулийг зөрчсөн эсэхийг нь тогтоогоод яваад байх ёстой юм биш юм уу гэдэг ийм асуудал үүсэж байгаа.

Үндсэн хуулиа барина гэвэл 29.3 дээр ингээд дахиад заачихсан байна шүү дээ. Улсын Их Хурлын гишүүн тангаргаасаа няцаж, Үндсэн хууль зөрчсөн бол Улсын Их Хурлын гишүүнээс эгүүлэн татах үндэслэл болно гээд. Ингээд хууль байхгүй юу даа. Бид ямар ч шийдэл байхгүй юм шиг юм яриад байгаа байхгүй юу. Энэ чинь Үндсэн хууль шүү. Цэцийн дээр Үндсэн хууль байх ёстой бол би Үндсэн хуулийн зүйл, заалтыг дурдаж байна. Үндэслэл болчихлоо, тэгвэл яах юм бэ гээд цаашаа дахиад хөөгөөд явна биз дээ энэ чинь. Тэгэнгүүт Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 9.3, 9.4 дээр чинь дахиад заачихсан байна. Улсын Их Хурлын гишүүн тангаргаасаа няцаж, Үндсэн хууль зөрчвөл яах юм бэ гэдгийг нь. Хүлээн зөвшөөрсөн бол Төрийн байгуулалтын байнгын хороо хуралдаж, шийдвэр гаргана гэж байгаа юм. Зөвшөөрсөн бол гэж байгаа юм. Шийдвэр гаргана, шийдвэр гаргаад яах юм бэ гэнгүүт тэр Төрийн байгуулалтын байгууллагын шийдвэр дээр үндэслэж гэж байгаа шүү энэ удаад бол жинхэнэ үндэслэж, Улсын Их Хурлын гишүүдийн хуралд

оролцсоны олонхоор буюу нууцаар санал хураана гээд дахиад цагаан дээр хараар биччихсэн.

Энэ эргээд энэ Үндсэн хуулийн зөрчил юунаас үүссэн бэ гэвэл Ерөнхий сайдыг огцруулах асуудал дээр чинь Төрийн байгуулалтын байнгын хорооны дүгнэлтийг одоо тэр Улсын Их Хурал дээр үндэслэдэггүй байгаадаа асуудал үүсчихсэн шүү дээ. Бид бүгд мэдэж байгаа шүү дээ. Дэгийн тухай хууль дээр ч байна 101.3. Одоо энэ Даваасүрэн гишүүн нэг юм яриад байгаа юм. Бүх асуудлыг Байнгын хороогоор оруулаад, Байнгын хорооны дүгнэлтэд үндэслэж, Улсын Их Хурал хэлэлцэнэ гээд байгаа юм. Үгүй шүү дээ. Дүгнэлт гэж байна нэг, томьёолол, Байнгын хороо бол томьёолол гаргадаг. Байнгын хорооны томьёоллоор, Байнгын хорооны саналаар, 2 асуудал дээр Байнгын хороог, хорооны дүгнэлт дээр үндэслэдэггүй. Үгүй ээ, тэгвэл энэ Үндсэн хуулийн цэц чинь буруу дүгнэчихсэн байна шүү дээ.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Гишүүд үгээ хэлж дууслаа. 1 минут байхгүй, 4 минутаар явж байгаа Баярмаа гишүүнээ. Дэг дээр асуулт, хариулт нь 3 минут, үг хэлэх бол 4 минут гэж байгаа. Таных сая 4 минутаар явсан гэдгийг хэлье. Гишүүд үг хэлж дууслаа.

Ер нь Жаргалан гишүүний хэлдэгтэй санал нэг байна. Цаашдаа бол үр дагаврыг арилгах үүднээс Хууль зүйн байнгын хороо, Төрийн байгуулалтын байнгын хороо бараг хамтарч ажлын хэсэг гаргаж, холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах, сайжруулах, засаж залруулах ажлыг хийх ийм шаардлага хэрэгцээ байна гэж бодож байна. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т Улсын Их Хурлын дэд даргыг огцруулах асуудлыг нэр дэвшүүлсэн нам, эвслийн бүлгийн хүсэлтээр шийдвэрлэхээр заасан бөгөөд Үндсэн хуулийн цэцийн 08 дугаар дүгнэлтийн нэг дэх хэсгийн хүрээнд Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлэг Үндсэн хууль зөрчсөн албан тушаалтнаа Улсын Их Хурлын дэд даргыг огцруулах хүсэлтээ Улсын Их Хуралд оруулан нэгдсэн хуралдаанаараа шийдвэрлүүлэхээр байна.

12.32 цаг

Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаан хаасныг мэдэгдье.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА